



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/100

Шивээговь сум

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/172 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 34 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан Шивээговь (22 дугаар) зөрлөгийн гармын хяналтын постон дээр эмнэлгийн шинжилгээний цэгийг байгуулж, 08:00-21:00 цаг хүртэл ажиллуулсугай.

2. Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан (буяны ажил, эрүүл мэнд, албан томилолт)-аар ирж буй иргэдээс түргэвчилсэн шилжилгээг үнэ төлбөргүй авах, бусад шалтгаанаар ирж байгаа иргэдээс түргэвчилсэн шинжилгээг 25000 (хорин таван мянга) төгрөгөөр авч сум руу нэвтрүүлэхийг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг)-т, гарам дээр ажиллах Эмнэлгийн шинжилгээний цэгт Шивээ-Овоо хувьцаат компанийн Гамшгаас хамгаалах Мэргэжлийн ангийн эмч нарыг татан оролцуулж, ажиллуулахыг Шивээ-Овоо хувьцаат компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга (Ц.Амарсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

42121-486

3. Улаанбаатар хот болон халдвартай бүс нутгаас ирэх хүсэлтэй харьяаллын бус иргэдийг хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд сум руу нэвтрүүлэхгүй, гармын хяналтын постоор орох, гарах хөдөлгөөнийг оройн 21:00 цагт хааж, хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байхыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

4. Иргэдэд Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, зарлан мэдээллийг чанга яригчаар тогтмол өгч ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүн (Э.Төрмандах)-д, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ